



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 9/36

Дэлгэрхаан сум

Бүх нийтийн их цэвэрлэгээ зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5.2, 10 дугаар зүйлийн 10.2.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын төвийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хаврын бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг 2026 оны 4 дүгээр сарын 03-ний өдрөөс 04 дүгээр сарын 08-ны өдрийг хүртэлх хугацаанд нийтийн эзэмшлийн газар, тоглоомын талбай, хайс хашаа, хогийн сав, аж ахуйн нэгж байгууллагуудын гадна талбай, хуваарьт газрын хогийг цэвэрлэх ажлыг зохион байгуулсугай.

2.Бүх нийтийн их цэвэрлэгээнд хяналт тавих, зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, цэвэрлэгээнд хамтран оролцох байгууллага, зохион байгуулах төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, их цэвэрлэгээний ажилд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг өргөнөөр татан оролцуулахыг багийн Засаг дарга нарт, тээвэрлэлт, цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг ачиж тээвэрлэх ажлыг зохион байгуулахыг "Тохижилт, цэвэрлэгээ, үйлчилгээ" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дарга (Ц.Адъяахүү), иргэд олон нийтийг татан оролцуулах, уриалга гарган зар хүргэх ажлыг хариуцан хэрэгжүүлэхийг байгаль хамгаалагч (Х.Мөнхбат) нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Батнасан)-д даалгасугай.

ДАРГА / Х.Мөнхбат / Д.Батнасан ЗНХ-АМГАЛАН



2326910972

Дэлгэрхаан сумын Засаг даргын 2026 оны  
04 дүгээр сарын 03-ны 2/36 дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт



### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Д.Батнасан  
(Засаг даргын орлогч)

Гишүүд:

Д.Урангоо

(Засаг даргын Тамгын дарга)

У.Ариунтуяа

(Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Х.Мөнхбат

(Байгаль хамгаалагч)

Б.Мөнхболд

(Багийн Засаг дарга)

Г.Батнасан

(Багийн Засаг дарга)

Д.Оюунчимэг

(Багийн Засаг дарга)

Б.Бүжинлхам

(Багийн Засаг дарга)

Ц.Адъяахүү

(ОНӨААТҮГазрын дарга)

Дэлгэрхаан сумын Засаг даргын 2016 оны  
08 дүгээр сарын 03 -ны 2/36 дугаар  
захирамжийн 02 дүгээр хавсралт



ЦЭВЭРЛЭГЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
1	Гудамж, зам талбай, голын ай сав газар, айл өрх аж ахуйн нэгж байгууллагуудын хог хаягдлын ачилт, тээвэрлэлтийн ажлыг эрчимжүүлэх	04.03-04.08	Байгаль хамгаалагч, багийн дарга нар, ААНэгжүүд, АБайгууллагын дарга нар ОНӨААТҮГ
2	Цэцэрлэгт хүрээлэн, наадмын талбай, морь барианы талбайн хог цэвэрлэгээг хийлгэх	04.03-04.08	ОНӨААТҮГ (Ц.Адьяахүү).
3	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гадна орчныг угааж цэвэрлэх	04.03-04.08	ЕБСургуулийн захиргаа, СӨБ
4	Хийгдэж байгаа ажлын явцын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр иргэд, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудыг сурталчлах	04.03-04.08	Аварга багийн дарга, Хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
5	Нийтийн эзэмшлийн талбайг ААНэгж, АБайгууллагууд хувиарлсан талбайг цэвэрлэх	04.03-04.08	ААНэгж, АБайгууллгын ажилчид
6	Зөвшөөрөлгүй газар хог хаягдал хаясан тохиолдолд зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ тооцох	Тухай бүр	Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн

ЗАСАГ ДАРГА БАТЛАВ Б.ЭНХ-АМГАЛАН

2026 оны 04 дүгээр сарын 03

СУМЫН ТӨВД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖҮҮД,  
АЙЛ ӨРХИЙГ БҮХ НИЙТИЙН ХОГ ЦЭВЭРЛЭГЭЭГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

2026 оны 04 дүгээр сарын 03

Аварга

**Зорилго:** Сумын хэмжээнд Орчны эрүүл мэнд, хөрсний бохирдлыг бууруулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах таатай нөхцөл бүрдүүлэн, Төр, иргэн, аж ахуйн нэгж хоорондын хамтын ажиллагааны идэвхтэй оролцоог дэмжин, "ӨНГӨ НЭМБЕ" уриан дор нэгдэхэд оршино.

**Хамрах хүрээ:** Сумын төвд оршин суудаг өрх, үйл ажиллагаа явуулдаг албан байгууллага, ААНэгж, иргэн хамрагдана.

**Хугацаа:** 2026 оны 04 дүгээр сарын 03-08 өдөр


**Байгаль орчны тухай хуулийн хэрэгжилт:**

- Байгаль орчны хамгаалах тухай хууль,
- Хог хаягдлын тухай хууль,
- Орчны эрүүл ахуйн тухай,
- Усны тухай хуулийг хэрэгжүүлэх

**Ажлын чиглэл :**

- Айл өрхүүд хашааны урд хойд талын хогийг цэвэрлэн хогны машинд ачуулах
- Албан байгууллага ААНэгжүүд тойм зурагт хуваарлсаны дагуух талбайн хог хаягдлыг цэвэрлэх
- Албан байгууллага, ААНэгжүүд байгууллагын гаднах өнгө үзэмжийг сайжруулж хог хаягдлыг цэвэрлэж хогны машинд ачуулах
- Удирдамжийн дагуу хийгдсэн ажлыг илтгэх хуудасаар Засаг даргад танилцуулах:

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:

БАГИЙН ДАРГА  Б.МӨНХБОЛД

